

МОНГОЛ УРАН ЗОХИОЛЫГ АНГЛИ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН НЬ

Н.Оюунзаяа¹³, А. Өлзийнаран¹⁴

Товч утга: Энэхүү өгүүлэлд манай нэрт орчуулагчид аливаа монгол уран зохиолыг англи хэлээр хэрхэн яаж буулгаж байсан талаар өгүүллээ.

Түлхүүр үг: монгол уран зохиол, нэрт төлөөлөгчид, монголын орчуулагчид, найруулгазүй, орчуулгын арга хэлбэр

Монголын утга зохиолыг англи хэл рүү орчуулж эхэлсэн нь “Монголын нууц товчоо”-ноос эхтэй. “Монголын нууц товчоо”-ны гадаад хэлээр гарсан зуу гаруй хэвлэл байдаг ч англи хэл рүү орчуулсан нь нилээн хэд бий. Эдгээрээс хамгийн анхных нь Америкийн судлаач Кливезийн орчуулга юм. Түүнчлэн “Библийн хэллэгийн хэлбэрээр махчлан орчуулсан” Рахвилзийн орчуулга, тайлбар ихээхэн алдартай нь юм. Мөн Онон Өргөнгөөгийн нэгэн орчуулга бий. Цаашилбал, Пол Каны “найруулсан” гэж өөрөө нэрлэсэн нэгэн сонин орчуулга [“The Secret History of the Mongols” (The Origin of Chinggis Khan)] бий. Пол Кан тэрхүү найруулгаа Кливезийн орчуулгад түшиглэн хийжээ. Түүний “найруулсан” гэдэг нь шүлэглэлээ гэсэн үг юм.

Чингэхдээ Жон Кругерийн монгол шүлгийн талаар дэвшүүлсэн санааг баримталсан байна. Кругер бичихдээ: “The major characteristics of Mongolian verse are the presence of alliteration at the beginning of verses, a frequent parallelism of phrasing and internal structure, with a definite tendency to restrict the verses to a fixed number of syllables, usually seven or eight, but sometimes longer.... Mongolian verse does not require (except as some modern authors may choose such forms) a regular alternation of stressed and unstressed syllable according to some predetermined pattern, but it does require alliteration, and without alliteration there can be no poetry in the Mongolian sense of the term”¹⁵ буюу “монгол шүлгийн хамгийн гол шинж бол шүлгийн эхэн дэх толгой холбоц, мөн тухайн тогтсон үеийн тоонд шүлгийн шадьг хязгаарлах хандлагатай үг хэллэг болон шадьдны дотоод бүтцийн эн зэрэгцүүлэл юм. Тогтсон үе нь ихэвчлэн долоо юм уу найман үе, заримдаа түүнээс ч урт үе байж болно. монгол шүлэг нь (орчин үеийн зарим нэгэн зохиолчид ийм хэлбэрийг сонгож болох ч) урьдаас сайтар бодож боловсруулсан загварын дагуу өргөлттэй болон өргөлтгүй үеийн жигд сэлгээг шаарддаггүй.

¹³ МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш

¹⁴ МУИС, ШУС, ХУС-ын ИБАСТ-ийн багш

Гэвч монгол шүлэгт толгой холбоц зайлшгүй хэрэгтэй бөгөөд толгой холбоцгүйгээр шүлэг гэдэг ойлголт нэр томъёоны хувьд монгол ухагдахуунд оршин тогтнодоггүй байна.” гэжээ.

Кругер ийнхүү монгол шүлгийн айзам үүсгүүрийг холбох, үг хэллэг, дотоод бүтцийг зэрэгцүүлэх, чингэхдээ үеийн тоог ихэвчлэн долоогоос наймаар, заримдаа арай олон байхаар хязгаарлах хандлагатай байдаг тухай өгүүлжээ. Мөн өргөлттэй, өргөлтгүй үеийн тоог тэнцүүлэх шаардлага байдаггүйг бас дурдсан байна. Үүгээрээ монгол шүлгийг үеийн шүлэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Энэ нь оросын монголч эрдэмтэн Л.Герасимовичийн “Авиан зүйн аргаар үзсэн туршилтаас үзэхэд 1) монгол хэлний үгийн тэргүүн үед тогтвортой ногдох хүчтэй, хүчлэх өргөлт байхгүй байна 2) үгийн тодорхой нэг үеийг тууштай ялгаруулдаг бөгөөд уг хэлээр яригчийн тод мэдэрч байдаг өргөлт ерөөс байхгүй байна” гэсэнтэй авцалдаж байна.

Мөн Д.Цэрэнсодномын “мөр бүрийн үеийн тоо тэнцүүлэх хандлагатай байдаг” гэсэнтэй ч тохирч байна.

Г.Акимын “Монгол шүлгийн айзам үүсгүүр нь үе, иймд монгол шүлэг бол үеийн шүлэг”[4] гэсэн дүгнэлттэй ч авцалдаж байна. Кан “Нууц товчоон”-ыг найруулахдаа Кругерийн дэвшүүлсэн дээрх саналыг баримталжээ. Энэ тухайгаа тэр бичихдээ: “I have made every attempt to preserve the parallelism of phrasing and structure, whether the original passage is alliterative or not. This “thought rhyme” is the aspect of Mongolian poetry that can best be conveyed in English. An attempt to reproduce the opening alliteration of syllables would be as forced as attempts to translate end rhymes. So far as I know it has wisely been avoided by everyone” буюу “Үндсэн эх зохиол нь толгой холбосон ч бай үгүй ч бай, үг хэллэг болон өгүүлбэрийн бүтцийн эн зэрэгцүүллийг орчуулгандаа хадгалж үлдэхийн тулд би бүх л аргыг хэрэглэсэн бөгөөд ийнхүү “сайтар нягталж боловсруулсан айзам” нь англи хэл рүү хөрвүүлж болох Монгол яруу найргийн нэг шинж юм. Эхний үеийн толгой холбоцыг орчуулганд буулгах нь сүүл холбоцыг буулгахтай адил хүчилсэн хэрэг болох байлаа.

Тиймээс миний л мэдэхээс хүн болгон үүнээс их ухаалгаар зайлсхийж байгаа болов уу” гэжээ. Үүгээрээ Кан монгол шүлгийн толгой болон сүүл холбоцыг англи хэл рүү буулгахдаа хэт хүчилж хиймлээр орчуулж болохгүй талаар өгүүлсэн байна.

“Нууц товчоон”-ыг Н.Доржготов, З.Эрэндоо нар англи хэл рүү 2006 онд орчуулсан. Энэ хоёр орчуулагч гадны эрдэмтдийн орчуулахдаа алдсан зарим алдааг залруулсан нь сайшаалтай. З.Эрэндоо бичихдээ: “Бидний орчуулга сонгомол эхтэйгээ аль болох ойр байхын зэрэгцээгээр өргөн олон нийтэд нэн

ойлгомжтой байх шаардлагатайг их анхаарсан” гэжээ. Энэ нь утгыг гаргах, уншигчаа бодох гэсэн хоёр зарчмыг харгалзаж үзсэн гэсэн үг юм.

Ер нь монголын уран зохиолыг гадныхан орчуулсан нь тун ховор. Харин өөрсдөө цөөн тооны орчуулгыг хийж байсан. Үүнд: Орчуулагч Дэмбэрэлийн Нацагдорж, шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч, зохиолч Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс”, “Цагаан сар ба хар нулимс” өгүүллэг, мөн “Эрийн гурван наадам”, Л.Хуушааны “Фидель Кастро” зэрэг томоохон найраглалуудыг орчуулсан бөгөөд орчуулагч Б.Дамдин, зохиолч Д.Нацагдоржийн “Шувуун саарал”, Б.Ринчений “Нууцыг задруулсан захиа”, “Ану хатан”, орчуулагч Т.Гомбосүрэн, Б.Ринчений “Шүхэрч Буниа”, “Гар”, Д.Лхамсүрэнгийн “Өнжүүлийн цагаан чулуу”, Э.Сэнгээгийн “Тагтаа”, Л.Түдэвийн “Хоёр улиас”, С.Удвалын “Баглаа цэцэг” зэрэг өгүүллэг, шүлгийг орчуулсан байдаг.

1976 онд Д.Нацагдоржийн “Од” түүврийг, 1978 онд “Учиртай гурван толгой” (“Three fateful hills”) түүврийг орчуулан гаргажээ. Энэ түүвэрт “Миний нутаг” (“My native land”) -ийг Г.Ринчендорж, “Учиртай гурван толгой” (“Three fateful hills”)-г Д.Алтангэрэл, Каролин Хампри нар орчуулжээ. Харин “Од” (“Star”) шүлгийг Каролин Хампри орчуулсан байна.

Мөн “Some short stories from Mongolia” түүвэрт орсон өгүүллэгүүдийг Дэ.Нацагдорж, Б.Дамдин, Т.Гомбосүрэн, Д.Алтангэрэл, Б.Чинбат, Д.Цэрэннадмид нар орчуулсан байна.

Монголын зохиолчдын зарим шүлгийг Ази, Африкийн зохиолчдын “Lotus” (Лянхуа) цоморлигт нийтэлж, чингэхдээ орос хэлнээс дам орчуулан нийтэлж байсан явдал бий. Жишээлбэл: Б.Явуухулангийн “Говь”, “Эх орон”, “Аморэ” шүлгийг Нихад Салем англи хэлнээ орчуулан тус сэтгүүлд хэвлүүлсэн байдаг.

Мөн сүүлийн үед манай зарим яруу найрагчдын бүтээл, тухайлбал, Б.Явуухулан, Г.Мэнд-Ооёо гэх мэт зохиолчдын бүтээл “Gunu” International Poetry and Literature magazine, сэтгүүлд англи хэлээр хэвлэгдсэн байна.

“Anthology of Mongolian poetry” түүврийг Ж.Гэндэндарма орчуулсан бөгөөд энд Г.Мэнд-Ооёо, Ц.Бавуудорж, Ж.Дашдондог, Э.Хархүү, Б.Чимэд, Ц.Ганхуяг, Л.Мөнхтөр, Ж.Гэндэндарма нарын шүлгүүд орсон байна. Орчуулагч Д.Алтангэрэл нижгээд зохиол бүтээлийг англи хэл рүү орчуулан “Modern Mongolian folktales and stories” (1979 он), “Modern Mongolian poetry” (1989 он), “Mongolian steppe and poetry” (1999 он) зэрэг номнуудаа хэвлүүлжээ. Мөн Д.Цэрэндорж, Д.Нацагдоржийн “Үзэгдээгүй юм”, Ч.Бүрэнбаяр, Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн”, “Солийг сольсон нь”, Д.Хандбалдир, Ц.Дамдинсүрэнгийн “Хоёр цагаан юм”, Б.Чинбат, Б.Баастын “Элсэн манхан далай” гэх мэт зохиол бүтээлийг орчуулсан байна.

Сүүлийн үед зарим нэг гадаадын орчуулагчид манай монголын уран зохиолын өв сангаас англи хэлнээ орчуулж байна. Үүнд Майкл Кон, Саймон Уикхэм Смит нарыг дурдаж болно. Энэ хоёр орчуулагч хоёулаа Д.Данзанравжаагийн [24] бүтээлээс орчуулсан байдаг юм байна.

Англи хэлээр гарсан бие даасан, томоохон бүтээл бол Говийн Догшин Ноён Хутагт Данзанравжаагийн “Үлэмжийн чанар” (“Perfect Qualities”) түүвэр юм. Уг түүврийг Саймон Уикхэм Смит орчуулжээ. Саймон орчуулгынхаа оршилд Данзанравжаагийн шүлгүүдийг орчуулсан тухайгаа бичихдээ: “In terms of literary style, these poems present a number of challenges. Danzanravjaa often employs a technique, common to Mongolian poetry, in which each line starts with the same letter and/or ends with the same word. This is not, of course, a common feature of English poetry; nonetheless, aware of the restraining dissimilarities of Mongolian and English grammar, I have sought in most cases to indicate structurally such repetition of individual words and phrases and, when the result did not prove too awkward, to start each line of a given poem with the same letter. In terms of cultural translation, as I have already pointed out, there are situations in which a direct translation might prove ugly and cumbersome. There is, however, just one term which I have shifted wholesale into a western context. The Mongolian word Erleg can be variously rendered - for instance, as “The king of the Underworld” or “Lord of Death” - but here I have chosen throughout to translate it as “Grim Reaper”, since I feel that there is a humorous aspect to Danzanravjaa’s invocation of this character which seems also to be expressed in this English term” буюу “Утга зохиолын найруулгын хэв маягийн хувьд эдгээр шүлэг нь маш их ур чадвар сорьсон бүтээл юм. Д.Данзанравжаа, мөр бүр нь ижил үсгээр эхлэх юм уу ижилхэн үгээр төгсдөг монгол шүлгийн нийтлэг арга техникийг их хэрэглэж бичдэг байжээ. Мэдээжийн хэрэг энэ нь англи яруу найрагт зонхилдог нийтлэг шинж биш боловч монгол, англи хоёр хэлний хэл зүйн дүрмийн ялгаатай талыг аль болохоор хязгаарлан, тухайн өгөгдсөн шүлгийн мөр бүрийг ижилхэн үсгээр эхэлснийг орчуулгандаа буулгах нь ихэнх тохиолдолд тийм ч их үр дүнтэй болж өгөхгүй, болхи сонсогдоод байх үедээ үг болон үг хэллэгийн давталтыг бүтцээр нь тодорхойлох арга замыг би эрэлхийлсэн билээ. Соёлын орчуулгын тухайд, урьд нь цохон тэмдэглэж байсан члан, эх шүлгийг шууд үгчлэн буулгах нь таагүй сонсогдох төдийгүй хэт нүсэрдээд байх тохиолдлууд байсан. Гэсэн хэдий ч нэг нэр томъёог бүхлээр нь барууны хам сэдвээр сольж орчуулсан болно. Эрлэг гэдэг монгол үгийг янз бүрээр орчуулж болно. Жишээ нь: “Доод Ертөнцийн Хаан” (The King of the Underworld), эсвэл, “Үхлийн эзэн” (Lord of Death) гэх мэт. Энэ дүрийг бүтээхдээ Д.Данзанравжаагийн онгодонд хошин өнгө аяс байгааг би мэдэрсэн учраас дээрх үгийг “Grim Reaper” гэж орчуулсан болно. Энэхүү англи үгэнд дээрх утга агуулагдаж байгаа юм.” гэжээ.

ДҮГНЭЛТ

Монголын орчуулгын онол, уламжлал өнө эртний түүхтэй агаад өдгөө бидэнд Хувилай хаан, Хайсан Хүлэг хаан, Есөнтөмөр хааны үед хийгдэж байсан болон хойшхи үеийн зарим орчуулгын судар бичгүүд уламжилж ирсэн байна. Монголын болон гадаадын эрдэмтэн судлаачид, гүүшүүдийн хийсэн орчуулгын ажил, баримт сэлтүүдэд хийсэн судалгаа, дүгнэлтүүдээс үзвэл, манай орчуулагчид үгчилсэн орчуулгын арга барилаас яваандаа утачилсан орчуулгын арга барилд шилжжээ. Харин хожим хорьдугаар зуунд европ зүгийн хэлнээс орчуулах онолын эх үүсвэрийг тавигчид болох Ц. Дамдинсүрэн үүргээр дүйлгэх үзэл баримтлал, Б. Ринчен хэм хэмжээ-агуулгыг тохируулах үзлийн тухай өгүүлж энэхүү орчуулах зарчмын үндсийг тавьсан байна.

Манай уран зохиолыг англи хэлнээ орчуулах ажил “Монголын нууц товчоо”-г АНУын нэрт эрдэмтэн Кливезээс эхэлж, 1960-1970 оны үед бэлтгэгдсэн манай үндэстний сэхээтнүүдээр үргэлжилсэн юм. Эдгээр орчуулагчид Д.Нацагдорж, Б.Ринчен, Л.Түдэв, С.Удвал нарын өгүүллэг, шүлгүүдийг орчуулж хэвлүүлэхийн зэрэгцээгээр Ази, Африкын зохиолчдын “Лянхуа” цоморлигт нийтэлж байв. Гэвч бүхэлд нь авч үзвэл, монгол уран зохиолыг англи хэлнээ орчуулсан байдал нь харьцангуй чамлалттай байгааг дурдах нь зүйтэй бөгөөд монгол зохиол бүтээлийг цаашид улам олноор яруу чанарын өндөр түвшинд орчуулж, хэвлүүлэх нь дамжиггүй.

Ашигласан номзүй

1. Адъяа.О, Дашдаваа.Д, Орчуулгын гарын авлага УБ., 1983 он
2. Аким.Г, Орчуулгын санг уудлахад, 1984 он
3. Аким.Г, Орчуулгын санг уудлахад, 2009 он
4. Аким.Г, Монгол шүлгийн айзам үүсгүүрийн асуудалд “Яруу найргийн орчуулгын түлхүүр” эмхтгэл, эрхэлсэн Г.Мэнд-Ооёо, УБ., 2006 он
5. Алтангэрэл.Д, Modern Mongolian poetry, 1986он
6. Алтангэрэл.Д, Mongolian steppe and poetry, 1999 он
7. Алтангэрэл.Д, Mongolian folk tales and stories, 1979 он
8. Вопросы теории перевода в зарубежной лингвистике, 1978 он
9. Герасимович.Л.К, Монгольское стихосложение Л., 1975 он
10. Герасимович.Л.К, Литература Монгольской Народой Р 1921-1964 годом. 1965он
11. Герасимович.Л.К, History of modern Mongolian literature (1921-1964), 1970 он
12. Гинзбург.Л, Вначале было слово /мастерство перевода/ М.,
13. Гүрбазар.А, Орчуулгын онол, дадлагын үндэс УБ., 1996 он
14. Гэндэндарам.Ж, Anthology of Mongolian Poetry УБ., 2007 он
15. Дамдинсүрэн.Ц, Selected short stories, 1978 он

16. Дамдинсүрэн.Ц, Олег цэцний орчуулгын тайлбар, “Монгол хэл бичгийн тухай” УБ., 1957он
17. Дашдаваа.Д, Орчуулгын зарим асуудал УБ., 1977 он
18. Доржготов.Н, “Нууц товчоо”-ны зарим үг, мөн хэллэгийн монгол, англи орчуулгын тухай “Монголын нууц товчоо зохиолын гадаад орчуулга” эмхтгэл, эмхтгэл эрхэлсэн Ц.Саранцацрал, УБ., 2006
19. Оюун-Ундраа.Н, Оюунзаяа.Н, Дуслын хэлхээс, 2008 он
20. Из монгольской поэзии XX века, 1981 он
21. Инжинаш, Хөх судар, тэргүүн дэвтэр, УБ, 2006 он
22. Жаргалсайхан.Ч, Дашдоржийн Нацагдоржийн зарим зохиол бүтээлийн Орос орчуулгын шинжилгээ, 2007 он
23. Зава Дамдин, Хор Чойнжун, 2007 он
24. Lama of the Gobi, Michael Kohn, 2006 он
25. Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл, 1957 он
26. Монгол хэлний товч тайлбар толь I,II боть
27. Монгол хэлний хэл зүйн толь бичиг I,II боть, 2006 он
28. Монголын сонгомол яруу найраг, 2008 он
29. “Монголын нууц товчоо”-ны зарим үг хэллэгийн талаар, “Монголын нууц товчоо зохиолын гадаад орчуулга”, Эмхтгэл. УБ., 2006 он
30. Мэнд-ооёо.Г, Quick wit the camel, 2010 он
31. Мэнд-ооёо.Г, Parole nomade, 2010 он
32. Мэнд-ооёо.Г, A patch of white mist, 2010 он
32. Мэнд-ооёо.Г, Шагдарсүрэн.Цог, An anthology of Mongolian literature, 2008 он
34. Мэнд-ооёо.Г, Golden hill, 2007 он
35. Мэргэн.Ш, Их Юань гүрний үед хятад хэлээр зохиол бичиж байсан Монгол яруу найрагчдын бүтээлийн хятад эх, Монгол орчуулгыг харьцуулан судлах нь, 2009 он
36. Нацагдорж.Д, “Од”, “Ламбагуайн нулимс”, УБ., 1976 он
37. Нацагдорж.Д, Three fateful hills, УБ., 2007 он
38. Орчуулах эрдэм 1 УБ., 1972 он
39. Орчуулах эрдэм 2 УБ., 1976 он
40. Орчуулах эрдэм 3 УБ., 1982 он
41. Орчуулах эрдэм 5 УБ., 1988 он
42. Орчуулах эрдэм 6 УБ., 1989 он
43. Ренчин.Б, Марк Твений минь махы нь идэж дээ...!(эмхтгэсэн Г.Аким), 1991 он
44. Ренчин.Б, Lady Anu, 1980 он
45. Ринчен.Б, Шүлэг орчуулах эрдэм, “Орчуулах эрдэм”. Эмхтгэл. УБ., 1972 он
46. Ринчен.Б, Монгол бичгийн хэлний зүй. Дөтгөөр дэвтэр, УБ., 1967 он
47. Ринчен.Б, Сайхан санаачлага, Сургамжтай дүн, “Орчуулах эрдэм”. Эмхтгэл. УБ., 1972он

48. Сүхбаатар.Ц, Шүлгийн орчуулгыг шүншиглэе, УБ., 2006 он
49. Some short stories from Mongolia,УБ., 1988 он
50. Some modern Mongolian stories in Mongolian and English, УБ., 2005 он
эмхэтгэсэн С.Дугармаа, С.Нарантуяа
51. Simon Wickham Smith, Perfect qualities, 2006 он
52. Хөхөө Намжил (The legend of Cuckoo Namjil), 1985 он
53. Шархүү.А, Үндэстний соёлын ялгаа ба орчуулгын зарим асуудал, УБ.,
2005 он
54. Шагдарсүрэн.Цог, Smith, The best of Mongolian poetry, 2007он
55. Шагдарсүрэн.Цог, Smith, A very big white Elephant: new voices in
Mongolian Poetry, 2007он
56. Явуухулан.Б, Түүвэр зохиол, 1985 он
57. Поэзия Народной Монголии. том первый, 1985 он
58. Krueger, Poetical Passages in the Erdeni-Yin Tobci
59. Цэрэнсодном.Д, Монгол шүлгийн онол, түүхийн асуудал. УБ., 1977 он
60. Цэрэнсодном.Д, XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр, УБ., 1969
он
61. The secret history of the Mongols, The origin of Chinggis Khan, An
Adaptation by Paul Khan, Boston 2002